



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/52

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдааны 2021 оны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Баянмөнх, Галшар, Дадал сумын төвлөрсөн дулаан хангамжийн шугам сүлжээний ашиглагчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|-----------------------|----------------|--|
| Ажлын хэсгийн ахлагч: | Ц.Чогсомжав | Аймгийн Засаг даргын орлогч |
| Нарийн бичгийн дарга: | Н.Үнэнбат | Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн |
| Гишүүд: | Б.Дарханбаатар | Хуль, эрх зүйн хэлтсийн дарга |
| | Д.Эрхэмбаяр | Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн Хэнтий аймаг дахь орон тооны гишүүн |
| | Л.Баасанхүү | "Хэнтий Ус" ХХК-ний дулааны инженер |

2. Ажлын хэсгийн гишүүдийг удирдлага зохион байгуулалтаар хангаж, ашиглагч сонгон шалгаруулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Чогсомжав/-д даалгасгай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ



231010159